



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 52,056 /тавин хоёр мянга тавин зургаа/ ширхэг хувьцааг 100 /нэг зуу/ хувааж нэг бүр нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,205,600 /таван сая хоёр зуун таван мянга зургаан зуу/ ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцааг хуваахтай холбоотой ажиллагааг ажлын 10 өдөрт багтаан гүйцэтгэж, холбогдох тайланг ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН